

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”							
1.	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		-Оюуны өмчийн хяналтыг сайжруулах сургалтыг гаалийн газар, хороодын ГУБ нарт зохион байгуулсан байна. -Оюуны өмчийн хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.	- Сургалт Бүрдүүлэлтийн цахим төвд Оюуны өмчийн эрх& гаалийн хяналт сэдвээр Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Нэргүйтэй хамтран 2024 оны 11 сарын 19-ний өдрийн тус төвийн 48 гаалийн улсын байцаагч болон гаалийн улсын ахлах байцаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан. Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газар болон АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар, АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамтай хамтарсан “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг 2024 оны 04 сарын 25-ны өдөр зохион байгуулагдав. Тус сургалтад Зөрчилтэй тэмцэх газар, Эрсдлийн удирдлагын хэлтэс, Бүрдүүлэлтийн цахим төв, Мэдээллийн технологийн газар, Сургалтын төв, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, ГСГГ, СЭГГ, ДОГГ, ЗҮГГ, БӨГГ, ХОГГ-ын 35 албан хаагчдыг хамруулав. Энэхүү уламжлалт сургалт, хэлэлцүүлгийг Дэлхийн оюуны өмчийн өдөр болон Монгол Улсын оюуны өмчийг хамгаалах өдрийг тохиолдуулан жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулж байхаар тогтсон бөгөөд энэ удаагийн сургалт, хэлэлцүүлгээс эхлэн Гаалийн байгууллага хамтран оролцогч байгууллага болж байгаагаараа онцлог юм. 2.Сургалтын үр дүнг сайжруулах, гаалийн газар хороодод ажиллаж буй гаалийн улсын байцаагч нарыг гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлж ажиллах мэдлэг, чадвар олгох үүднээс	01.02 12.10	95

					дээрх сургалтыг газар хороодод дахин зохион байгуулан тайланг ирүүлэх талаар албан бичиг хүргүүлж, мэдээллийг нэгтгэн удирдлагад танилцуулав. 3.Оюуны өмчийн хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж ажилласан. 4.Мэдээллийн технологийн газарт гаалийн үйлчилгээний цахим систем gaali.mn системийн үйлчилгээ цэсний Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргах, баталгаажуулах хэсгийг хэрэглээн нэвтрүүлж CAIS системд холбох холболтыг хийлгэхээр МТГ-т хүсэлт 2024.05.07-ны өдөр болон 2024.10.22-ны өдөр хүргүүлсэн. -Оюуны өмчийн эрхтэй холбоотой бараанд тавих гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, <u>Гаалийн хяналтын стратегийг тодорхойлох:</u> Хуурамч бараа бүтээгдэхүүн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ноцтой эрсдэлд хүргэдэг тул: -хортой болон чанар муутай найрлагатай, идэвхтэй бодис агуулаагүй эмийн бүтээгдэхүүн, -аюулгүй байдлын стандартыг хангаагүй автомашины эд анги, -пестицид, хортон ургамал устгах бэлдмэл, ургамлын ургалт зохицуулах бодис, -согтууруулах ундаа зэрэг хуурамч бүтээгдэхүүний гаалийн бичиг баримтын болон биет шалгалтад хэрхэн хяналт тавих талаар системтэй ажил зохион байгуулахаар судалж байна. <u>Холбогдох яам, агентлагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох</u> -Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газар болон АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар, АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, Оюуны өмчийн газартай хамтарсан “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг 2024 оны 04 сарын 25-ны өдөр зохион байгуулав.		
--	--	--	--	--	---	--	--

					-БНХАУ-ын Бээжин хотод суух АНУ-ын ЭСЯ-ны Дотоодын аюулгүй байдал болон цагаачлал, гаалийн хяналт хариуцсан дэд атташе Стивен Тимминс, олон улсын компьютер хакердалт ба оюуны өмчийн асуудал хариуцсан зөвлөх Томас Софиа нартай уулзалт 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулсан. АНУ-ын Оюуны өмчийн мэргэжилтнүүд хуурамч болон жинхэнэ бараа бүтээгдэхүүнийг таних сургалтыг зохион байгуулах талаар санал солилцож 2025 оны 1-р улиралд тус сургалтыг хилийн Замын-Үүд болон Алтанбулаг боомтууд дээр хийхээр тогтов. -Монголын Оюуны Өмчийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн Холбоо буюу АМИПА (ASSOCIATION OF INTELLECTUAL PROPERTY AGENTS OF MONGOLIA)-ны зарим гишүүдтэй уулзалт зохион байгуулж, мэргэжлийн туслалцаа авах талаар хамтран ажиллаж байна. -Шмитт энд Орлов оюуны өмчийн фирмтэй хамтын амжиллагааны хүрээнд “Хуурамч бараа бүтээгдэхүүнийг хэрхэн таньж мэдэх вэ?” сэдэвт оюуны өмчийн цахим сургалтыг 2022 онд зохион байгуулсан. 2024 онд хилийн Замын-Үүд болон Алтанбулаг боомтуудад очиж танхимын сургалт хийхээр сургалтын төлөвлөгөөгөө боловсруулж, мэдээлэл солилцож байна. -Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн газар болон Хяналт шалгалтын газартай хамтран ажиллаж байна. Оюуны өмчийн газрын мэдээллийн технологийн ажилтан Сод-Эрдэнэтэй холбогдож https://publish.ipom.mn/wopublish-search/public/home?0 системийн талаар мэдээлэл авч, тухайн барааны тэмдэг /зохиогчийн, патент .../ бүрээр мэдээллийг татан авч линкээр сан үүсгэн хадгалах боломжтой болсон. Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны бүртгэлийг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулах цахимжуулах Гаалийн цахим үйлчилгээний gaali.mn системийн үйлчилгээ цэсний “Оюуны өмчийн эрхэд хамаарах		
--	--	--	--	--	---	--	--

					барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх” хүсэлт гаргах, баталгаажуулах хэсгийг хэрэглээнд нэвтрүүлж мөн CAIS системд холбох холболтыг хийлгэхээр МТГ-т хүсэлт 2024.05.07-ны өдөр болон 2024.10.22-ны өдөр хүргүүлсэн. 1. Хүсэлт хянах процесс -Оюуны өмчийн асуудал хариуцсан ГУБ ирсэн хүсэлтийг Cims.gaali.mn програмаар хүлээн авч хянаж, ХБГ-ын дарга руу баталгаажуулах хүсэлт илгээх, эсхүл хүсэлт гаргагч руу буцаах -Мөн баталгаажсан хүсэлтэд өөрчлөлт оруулах эрхтэй байх -Хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжийн дарга оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаальд бүртгүүлэх хүсэлтийг баталгаажуулах -Баталгаажуулах үйлдэл хийсний дараа QR код бүхий Баталгаажуулах маягтыг автоматжуулах, баталгаажсан маягт/хуудас нь хүсэлт гаргагч руу илгээгдэх эсхүл хүсэлт гаргасан цонх дээр нь харагдах -Өмнө үүссэн бүртгэлийг баазад байршуулах, эсхүл тухай бүртгэлийг үүсгэх эрхийг тавьж өгөх 2.Гаалийн ерөнхий газрын оюуны өмчийн асуудал хариуцсан албан хаагч хүсэлтийг хүлээн авч, тухайн оюуны өмчийн бараанд харгалзах БТКУС кодыг оруулан баталгаажуулснаар КАЙС-ийн мэдээллийн санд Оюуны өмчийн бүртгэл үүсэн хадгалагдах; 3.Иргэн, аж ахуйн нэгж гаалийн байгууллагад бараагаа мэдүүлэх үед гаалийн мэдүүлгийн Барааны нэр, төрөл, БТКУС кодын мэдээллийг дээрх бүртгэлд хамрагдсан <i>барааны нэр, марк, зориулалт, үйлдвэрлэгч, оноосон нэр</i>-ийн мэдээлэлтэй тулган шалгагдаж, БТКУС кодоос гадна багадаа 1 мэдээлэл тохирч байвал бичиг баримтын шалгалт хариуцсан болон хяналт шалгалт хариуцсан албан хаагчид анхааруулга мэдээлэл өгөх; 4. Анхааруулга дээрээс хариуцсан албан хаагчид тухайн оюуны өмчийн эрхэд хамаарах бүтээгдэхүүний КАЙС-д бүртгэгдсэн дэлгэрэнгүй		
--	--	--	--	--	--	--	--

					мэдээлэл рүү шилжин харах боломжтой байх байдлаар системийн хөгжүүлэлт хийлгэж байна. Одоогоор хүсэлтийг <u>Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем</u> /cims.gaali.mn/-ээр хүлээн авч, хянаж байна. Оюуны өмчийн газрын publish.ipom.mn системээс real time тухайн оюуны өмчийн эрхэд хамаарах барааны мэдээллийг шалгах боломжтой болгож, линкийг барааны бүртгэлд холбож өгсөн. Гаалийн байгууллагын бүртгэлд авагдсан оюуны өмчийн эрхэд хамаарах барааны бүртгэлийн жагсаалтыг шинэчлэв. Оюуны өмчийн эрх эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ 52 хуулийн этгээд, иргэний бүртгүүлсэн 138 барааны тэмдэг, Патент-2, ашигтай загвар-6, зохиогчийн эрх-1-ийг хянаж хугацаа дууссан ОӨЭ-д хамаарах барааны бүртгэлийг шинэчлэн, cais системд оруулах файлын сан үүсгэж эхэлсэн. 2023 он 2024 оны 10 сарын 29-30-ны өдөр зохион байгуулагдсан 21st CAP meeting хуралд цахимаар оролцож, мэдээлэл авсан.		
2.	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.	Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ГЕГ-ын ХХ-т сар бүр тогтмол хүргүүлсэн: УИХ-ЫН ТОГТООЛ: -2023 оны Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023 оны 06; ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ: -2023.05.03-ны 159 дүгээр тогтоолын 1; -2023.05.17-ны 178 дугаар тогтоолын 1; -2024.04.10-ны 150 дугаар тогтоолын 4; ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛ: -2022.05.11-ний 28-р тэмдэглэлийн ХҮЛ.4; -2023.10.04-ний 40-р тэмдэглэлийн 1, 2; ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР: -2022.12.16-ны 10-р даалгаврын 2;	01.02 12.10	100
3.	Нэгжийн эрсдэлийн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	-Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар	Нэгжийн чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг	01.02 12.10	100

	удирдлагыг хэрэгжүүлэх			ЭУХ-ээс зөвлөгөө, чиглэл авах ажлыг зохион байгуулсан байна.	бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлж, дараах чиглэлээр судалгаа хийсэн. Үүнд: 1.Хүний нөөц, бүтэц, зохион байгуулалттай холбоотой эрсдэл тооцох; 2.Нэгжийн үндсэн чиг үүрэг, чиг үүргийн харьцуулалт; 3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажил; 4.Нэг албан хаагчид ногдох ажлын ачаалалтай холбоотойгоор ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажил; 5.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байдал. Тус нэгжийн албан хаагч нар олон чиглэл хариуцаж, чиглэл тус бүрийг нарийвчлан судлах шаардлагатай байдаг. Иймд чиг үүргийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг дараах байдлаар тооцоолж, - эрсдэлийн зэрэглэл өндөр үнэлэгдсэн тохиолдолд түүнийг бууруулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх; -дунд түвшинд үнэлэгдсэн тохиолдолд байнга хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх; -бага түвшинд үнэлэгдсэн тохиолдолд эрсдэлийг тасралтгүйгээр хянан үзэхээр ажиллаж байна. Мөн доор дурдсан давуу болон сул тал, хүндрэлтэй асуудлуудыг таньж, тогтоон хянаж ажиллаж байна. Давуу тал: 1.Багаар ажиллаж, ажиллагсад хоорондын ажил үүргийг орлон гүйцэтгэх чадвартай албан хаагч нар ажилладаг; 2.Албан тушаалын чиг үүргийн хүрээнд авилга, ашиг сонирхлоос ангид байж, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигладаггүй; 3.Гаалийн байгууллагын бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг болох мөн чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, танилцуулгыг цаг тухай бүр ажил, амралтын цаг харгалзахгүйгээр гаргаж удирдлагад хүргүүлдэг; 4.Ажлын ачаалал даах чадвартай. Энэ нь албан хаагч нарын "Ажлын зураг авалтын хуудас"-аас харагдана;		
--	------------------------	--	--	---	--	--	--

					5.Ажлын бус цагаар, амралтын өдрүүдээр яаралтай мэдээ, танилцуулга бэлтгэх шаардлага тулгарахад шалтгаан тоочихгүйгээр тухай бүр ажиллаж чаддаг; 6.Шаардлага тохиолдсон үед эсхүл хэн нэг нь ачаалал ихтэй байх үед өөрийн чадахаар нэг нэгэндээ туслаж, ачааллаас нь хуваалцдаг. Сул тал /хүндрэлтэй асуудал/: 1.Шаардлагатай мэдээ тайлан богино хугацаанд гаргахад эрхийн хязгаарлалтай байдаг. Тухайлбал сар бүр Сангийн яаманд гаргаж хүргүүлдэг Гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс гаргах тоон мэдээллийг авах эрх байхгүй учраас СМТТ УТҮГ-т хандаж, тодорхойгүй хугацаагаар хүлээдэг; 2. Квот, ГИТ, гаалийн мэдүүлгийг татгалзах, хүчингүй төлөвт шилжүүлэх, горимд байршуулах хугацаа сунгах зэрэг нэгжийн чиг үүргийн дагуу зөвхөн тухайн асуудлыг хариуцсан ГУБ нарт байх шаардлагатай эрхүүдийг өөр бусад албан хаагч нар ашиглах боломжтой байгаа эсэхийг хянах боломжгүй байдаг; 3.CAIS-т нэвтрэхдээ тоон гарын үсэг ашиглахгүй байгаа нь нууцлал, аюулгүй байдлыг хангахгүй байна; 4.CAIS-аас шаардлагатай мэдээг татаж чаддаггүй, гар ажиллагаа ихтэй; 5. Сангийн яамнаас мэдээ, биелэлтийг хугацааг нь тулгаж, 2 цагийн дотор ирүүл эсхүл 10:10 цагт өгөөд 13:30 цагаас өмнө ирүүл гэх мэтээр шаарддаг. ХҮРСЭН ҮР ДҮН: 1.ХБГ-ын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлийг. -Бүтэц зохион байгуулалт; -Үйл ажиллагаа; -Хууль тогтоомж; -Мэдээллийн технологи гэсэн 4 чиглэлээр тодорхойлж гаргасан. 2.Хяналт, бүрдүүлэлтийн газрын үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулахын тулд дээрх эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйл бүртэй холбоотой эрсдэл гарах магадлал, үр дагаврыг 3x3 матрицын тусламжтай гаргасан. 3. Нийт 4 хүчин зүйлийн хүрээнд тодорхойлсон 8 эрсдэлээс 5 нь хамгийн өндөр, 3 нь бага эрсдэлийн		
--	--	--	--	--	---	--	--

					зэрэглэлтэй гэж үнэлэгдсэн тул хүчин зүйл тус бүрийн хүрээнд тодорхойлсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ тус бүрийг хариуцах эзнийг тодорхойлсон.		
4	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	1.Засгийн газрын 2023 оны 445 дугаар Журам, жагсаалт, үнийн дүн батлах тухай тогтоол, Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн НӨАТ-ын буцаан олголттой холбоотойгоор тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус ажлын хэсгийн vibeg группт нэгдэн, өдөр тутмын мэдээлэлтэй танилцан, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажилд санал хүргүүлэн, гаалийн байгууллагын оролцоог ханган ажиллаж байна. 2.Хяналтын тэмдэг захиалгыг гаалийн газар, хороодоос хүлээн авч шинээр үйлдвэрлүүлэн СХОГ-т хүргүүлэв. 6.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн дагуу 3 эрүүгийн хэрэгт гаалийн байгууллагыг төлөөлөн, хохирогч иргэний нэхэмжлэгчээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож 9 удаа АТГ-т очиж хэргийн материалтай танилцсан. 9.САIS системийн Эрсдлийн удирдлага / Зорчигч онилох модуль/ Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл шалгах цэс хийгдсэн. Цаашид НӨАТ-ын буцаан олголт авахаар системийн бүртгэл үүсгэн буцаан олголт авч байгаа гадаадын жуулчдын мэдээллийг САIS системд авахаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөн тусгахаар санал хүргүүлсэн. 10.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай (шинэчилсэн найруулга) хууль, Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт зэргийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан ХЦХ-тэй хамтран чиглэл хүргүүлж, зорчигчийн эмийн бүртгэлийн программын даалгаварт санал өгч, хэрэглээнд нэвтрэхэд бэлдсэн. Программын ажил Интерактив ХХК-д хийгдэж байна.	01.02 12.10	100

					11.2024.08.29-ний өдрийн ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн ахлах мөрдөгч Нямдоржийн дуудсанаар очин зорчигчид тавих гаалийн хяналт шалгалтын талаар мэдүүлэг өгсөн.		
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ.	2024 онд ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж: -гадаад сургалтын 1; -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 5; -ээлжийн амралтын 1; -хурлын өрөөний 2 буюу нийт 00 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан. 2024 онд 3409 минут илүү цаг ажилласан бүртгэл CERP-д байна.	01.02 12.10	100

Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Уулзалт зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Уулзалт зохион байгуулсан байна.	Зорчигчийн мэдээллийн төвийн дарга Энхтөр болон Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжийн удирдлагуудын уулзалт 2024 оны 02 сарын 19-ний өдөр зохион байгуулав.	02.19 02.19	100
2	Уулзалт зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Уулзалт зохион байгуулсан байна.	Гаалийн ерөнхий газар болон Монгол шуудан ХК, УХШИГГ-ын хамтарсан уулзалтыг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан.	06.26 06.26	100
3	Семинарт оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Семинарт оролцсон байна.	ОУВС-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн Томас Хансены "Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник" сэдвээр 2024.04.08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан семинарт оролцсон.	04.08 04.10	100
4	Цахим уулзалтад оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Цахим уулзалтад оролцсон байна.	Гаалийн ерөнхий газрын дэд дарга "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх баг"-ийн бүрэлдэхүүн, удирдамжийг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цэндсүрэнгээр ахлуулсан судалгааны багт ажилласан.	10.24 12.10	100

5	ЧХОУНБГ-ын үйл ажиллагааг танилцуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ЧХОУНБГ-ын үйл ажиллагааг танилцуулсан байна.	Синтетик төрлийн хар тамхины олон улсын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага (sddp-mc) төслийн хүрээнд дэлхийн гаалийн байгууллагын хууль сахиулах, худалдааг хөнгөвчлөх хорооны мансууруулах бодисын хөтөлбөр хариуцсан техникийн атташе Астрид Хэйтерийг хүлээн авч Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын хяналтын бүсүүдийг, мөн Чингисхаан Олон улсын нисэх буудал дахь карго терминал, Эрэлч нохойн сургалтын төвийн гаалийн хяналт шалгалт, хэрэг зөрчил илрүүлэх, эрсдэл тооцох үйл ажиллагааг тус тус 2024 оны 8 дугаар сарын 6-наас 7-ны өдрүүдэд зочдод танилцуулж, хамтран ажилласан.	08.06 08.07	100
6	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Уулзалтад оролцсон байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу Шуудангийн шинэчлэл дугуй ширээний уулзалтад ХБГ-ын дарга Б.Даваасүрэн, Д.Ням-Осорын хамт 2024.09.17-ны өдөр оролцсон.	09.17 09.17	100

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	БНХАУ-ын Худалдааны яамнаас Шаньдун мужийн Чиндао хотноо зохион байгуулж, Шаньдун Гадаад худалдааны мэргэжлийн Коллеж хариуцан гүйцэтгэсэн "Монголын цахим худалдааны семинар"-т Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/172 дугаар тушаалын дагуу нэр бүхий албан хаагчид болон Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг 5 байгууллагын төлөөлөл болох нийт 21 албан хаагчтай хамт оролцсон.	03.20 04.02	100
2	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	АНУ-ын Нью Йорк мужийн Зүүн Дүүргийн Шүүх, Аюулгүй байдлын мөрдөн шалгах алба, Патент, Барааны тэмдэгийн газрын Олон улсын харилцаа, бодлогын албаны ажилтанууд, АНУ-ын ЭСЯ, Оюуны өмчийн газар, ГЕГ-аас хамтран албан хаагч нарыг чадавхижуулах	04.25 04.25	100

	сургалтад хамрагдах		"Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдвээр зохион байгуулагдсан цахим орчин дахь эрхийн зөрчил, хуурамч барааг онолох, таних сургалтад оролцсон.		
3	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх онол, практикийн асуудал уулзалт, сургалтад Хяналт, бүрдүүлэлтийн газрыг төлөөлөвн оролцов.	09.25 09.25	100
4	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	Олон Улсын Валютын сангийн Хуулийн газраас 2024.10.09-11-ний өдрүүдэд Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх үйл ажиллагааны талаар ТЕГ-т зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	10.09 10.11	100
5	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна.	01.02 12.10	100
6	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	2024 оны 10 сарын 29-30-ны өдөр Дэлхийн гаалийн байгууллагаас зохион байгуулагдсан 21st CAP meeting хурал, сургалтад цахимаар оролцсон.	10.29 10.30	100
7	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	Татварын албадын хоорондын мэдээллийн солилцоо, зохицуулалтыг сайжруулах-Техникийн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн Мөнгө угаахтай тэмцэх (AML) сургалтад Татварын ерөнхий газарт очиж оролцсон.	10.09 10.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН
УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГ

Н.Ойнбилэг

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	50	4	54	
2	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	5	60	
3	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	55	6	61	
4	Үүрэг даалгаврын биелэлт	55	5	60	
5	Ажлын цаг ашиглалт	56	6	62	
Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт					
1	Уулзалт зохион байгуулах	60	10	70	
2	Уулзалт зохион байгуулах	60	10	70	
3	Семинарт оролцох	60	10	70	
4	Цахим уулзалтад оролцох	60	10	70	
5	ЧХОУНБГГ-ын үйл ажиллагааг танилцуулах	60	10	70	
6	Уулзалтад оролцох	60	10	70	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний	Нийт	Үнэлгээний багийн хянан
-----	----------------------------------	-------------------	------	----------------------------

		биелэлтийн хувь	(15 хүртэл оноогоор)	баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
2	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
3	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
4	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
5	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	100	15	
6	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
7	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
Дундаж оноо			13.7	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
-----	----------	---------------------------------

	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	65.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.7
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		93.4

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... (Б.Даваасүрэн)

.....(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:
Гаалийн улсын байцаагч

 (Н.Ойнбилэг)


.....(огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч


 (Г.Энхтайван)

 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч


 (Ө.Тэгшээ)

 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)

.....(огноо)